



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2001-2002 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Рэнцэн овогтой Баяртогтохыг Канад улсын Саскачеваны Их сургуулийн магистрантурт хөдөө аж ахуйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Пүрэвдорж овогтой Хангалыг Япон улсын Азийн Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Жамьяншарав овогтой Хишигбаярыг АНУ-ын Колорадогийн Улсын Их сургуулийн докторантурт экологийн чиглэлээр 3 жилийн хугацаагаар тус тус 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 378 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Handwritten notes and stamps on the left margin, including a date stamp "2002.04.29" and some illegible text.



САЙД

Баасанжав А.ЦАНЖИД

Хуучинбар үзэж, с/м Д.Мхитарян
2002.04.29

0330486